



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 4536

Номгон


Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 259 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/426 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж байгаатай холбогдуулан коронавируст халдвар тархах эрсдэлээс иргэд, олон нийтийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 00:00 цагаас 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 24:00 хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасугай.

2. Дээрх хугацаанд холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), Эрүүл мэндийн газар (Н.Энжаргал), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.



Д.МӨНХСАЙХАН